

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/02/СТА-ЗГТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймгийн Сайншанд сум

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734      Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч    Э.Энхцэцэг

Утас: 70523020      Цахим хаяг: injig78@yahoo.com

Аудитор:              Б.Отгон-Өлзий

Утас: 99844655      Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |

## Агуулга

---

|         |  |    |
|---------|--|----|
| 1       | Аудитын гэрчилгээ .....  | 3  |
| 2       | Аудитын тайлан .....   | 5  |
| 2.1.    | Оршил .....  | 5  |
| 2.2.    | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 5  |
| 2.3.    | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....  | 6  |
| 2.4.    | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....   | 6  |
| 2.5.    | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 7  |
| 2.6.    | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....  | 7  |
| 2.7.    | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....   | 7  |
| 2.8.    | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....  |    |
| 2.8.1   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар.....     |    |
| 2.8.2   | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....             |    |
| 2.8.2.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....                                   |    |
| 2.9.    | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                 |    |
| 2.10.   | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....   |    |
| 2.11.   | Шилэн дансны мэдээлэл.....   |    |
| 2.12.   | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....   |    |
| 2.13.   | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....  |    |
| 2.14    | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....  |    |
| 3       | Менежментийн захидал.....  | 11 |
| 4       | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 15 |

---

## 1 Аудитын гэрчилгээ


|  |   |
|--|---|
| <br><b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ<br/>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b><br>44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,<br>3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,<br>Утас: (705) 2-27-34<br>Вэб сайт: dornogovi@audit.gov.mn  | <b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН<br/>ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН<br/>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА<br/>Д.ЦЭНДМАА ТАНАА</b> |
| 2020.02.28 № 1-6/151   |   |
| танай _____ -ны № _____ -т   |   |
| <b>Аудитын гэрчилгээ</b>   |   |
| <p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>  |   |
| <b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>   |   |
| <p>Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p> |   |
| <b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>   |   |
| <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>                              |   |
| <p>Аудитаар Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>        |   |


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.АРИУНАА



## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Д.Цэндмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 сарын 04-ний өдрөөс 2020 оны 02 сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эрхэм зорилго нь төрөөс баримталж буй бодлого чиг үүргээ хэрэгжүүлж нийгмийн халамжийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай бодитой хүргэж, ард иргэдийг ажилтай орлоготой болоход нь хамгийн ойрын туслагч болж нийгмийн “Тулгуур хөтөч” болоход оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

- Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд мөрдөх дансны нэгдсэн төлөвлөлт байхгүй байна. Staus.audit.mn программтай уялдаагүй байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Геу-Окей ХХК-ний "AXPLOREER-3" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 20 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 524,483.1 мянган төгрөгөөс тооцон 5,244.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл их гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,212.1 мянган төгрөгөөр буюу 29.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлагын дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
|---|----------------|-----------------|-----------|
| Б   | 1              | 2               | 3=2-1     |
| Мөнгөн хөрөнгө                                    |                |                 |           |
| Авлага  | 919,849.4      | 1,188.061.5     | 268,212.1 |
| Урьдчилгаа  |                |                 |           |
| Бараа материал                                    |                |                 |           |
| Үндсэн хөрөнгө                                    |                |                 |           |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | 919,849.4      | 1,188.061.5     | 268,212.1 |
| Өр төлбөр   | 5,389.9        | 5,389.9         |           |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 914,459.5      | 1,182,671.6     | 268,212.1 |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | 919,849.4      | 1,188.061.5     | 268,212.1 |

Авлага дансны үлдэгдэл өссөн нь 100 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл, хоршоо, байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт тайлант онд шинээр 190,000.0 мянган төгрөг, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт шинээр 40,000.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт шинээр 165,000.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 24,000.0 мянган төгрөг тус тус олгосноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн 183.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. 4 төрлийн зээлийн 2014-2017 оны хугацаа хэтэрсэн 239,793.7 мянган төгрөгийн авлага байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн 5,389.8 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өмнөх оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн хэрэгжүүлээгүй байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлант онд 8,600.0 мянган төгрөгийн

орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 16,470.9. мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 191.5 хувиар биелүүлсэн байна.

## Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл                 | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү   | Хувь  |
|-------------------------------|------------|-----------|---------|-------|
| ХБИргэн ажиллуулаагүйн орлого | 8,600.0    | 16,470.9  | 7,870.9 | 191.5 |
| <b>Нийт дүн</b>               | 8,600.0    | 16,470.9  | 7,870.9 | 191.5 |

Зээлийн эргэн төлөлтийн орлого 249,229.3 мянган төгрөг байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 897,612.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 897,612.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 794,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,600.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг авч үзвэл 16,470.9 мянган төгрөг ХБИргэн ажиллуулаагүйн орлого төвлөрсөн байна.

Урсгал зардлын гүйцэтгэл 776,224.2 мянган төгрөг 86.5 хувьтай байгаа нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хөтөлбөрөөс 5,561.1 мянган төгрөг, ажилд зуучлах үйлчилгээнээс 1,608.8 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрөөс 11,928.0 мянган төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 38,683.0 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 11,580.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 24,815.8 мянган төгрөг, ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 18,531.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрөөс 1,995.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

**Хэмнэлтийн тодруулга:** Шаардлага хангахгүй төсөл орж ирсэн, ажлын байрны түрээсийн, борлуулалтын дэмжлэгээс хэмнэлт үүссэн байна.

### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 304,288.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 304,288.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 138 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 646,423.9 мянган төгрөгийн, 6 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсөл хөтөлбөр төлөвлөсөн хэмжээнд хэрэгжээгүйгээс 114,802,730 төгрөг зарцуулагдаагүй байна. Тухайлбал: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 38,683,000 төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 24,815,800 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 18,531,000 төгрөг, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөрийн ур чадвар олгох хөтөлбөрөөс 11,928,000 төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдсэн байна.
2. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар түүний харьяа газар, хэлтсүүдийн хэмжээнд мөрдөх НББББББичгийг баталсан байна. Энэ бодлогын баримт бичигт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хэмжээнд мөрдөх дансны жагсаалт тусгагдаагүй байна.
3. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар эргэн төлөгдөх төсөл хөтөлбөрүүдээс 1,188,061,452 төгрөгийн авлагатай, өмнөх оноос 268,212,093 төгрөгөөр үүнээс хугацаа хэтэрсэн зээл 187,659.3 мянган төгрөгөөр өссөн нь авлага бууруулах талаар ажил зохион байгуулаагүй байна.
4. Программ хангамж нь staus.audit.mn программ хангамжтай уялдаагүй тайлангийн тулгалт хийх хяналтад хүндрэл учруулж байгаа нь Сангийн яамнаас тавьсан шаардлагад нийцэхгүй байна.
5. Орлогын дансанд хэрэгжүүлсэн хяналтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй зөрчилд төлбөр төлөх шаардлага өгч

16,470,950 төгрөгийг төвлөрүүлэн, туслах аж ахуйн орлогоор тайлагнасан боловч өмнөх оноос 32,898,000 мянган төгрөгөөр буурч төлөвлөгөөг 91.5 хувь буюу 7,870.9 мянган төгрөгөөр давуулсан нь төсвийн төлөвлөлтийг бодитой хийхгүй байгааг харуулж байна.

6. Шатахууны зарцуулалтыг тогтоосон нормоор тооцож хянахад замын хуудсаар километрийн бичилт дутуу бичигдсэнээс 1,826.0 мянган төгрөгийн шатахуун тогтоосон хэмжээнээс илүү зарцуулсан харагдаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **3.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Төсөл хөтөлбөр төлөвлөсөн хэмжээнд хэрэгжээгүй байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Хөтөлбөр төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байх.

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсөл хөтөлбөрийг төлөвлөсөн хэмжээнд бүрэн хэрэгжүүлэх.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байхгүй**

### **3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансны төлөвлөгөө тусгагдаагүй.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тус тус зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

НБББББ-ийг байгууллагын онцлогт тохируулан шинэчлээгүй байх.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

НБББББ-т өөрчлөлт оруулж шинэчлэх.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байхгүй**

### **3.3 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

Өмнөх оноос авлага нийт дүнгээрээ болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өссөн.

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл: Авлага, өглөгийг барагдуулахгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

### **3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

#### **3.4.1 Илрүүлэлт:**

Программ хангамж нь staus.audit.mn программ хангамжтай уялдаагүй нь аудит хийхэд хүндрэл учруулсан, Сангийн яамнаас тавьсан шаардлагыг хангахгүй байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Тухайн байгууллагад ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн программ хангамж нь Сангийн яамнаас тогтоосон шаардлагыг хангаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж: Сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн яамнаас зөвшөөрөгдсөн, бусад программтай уялдаатай программ ашиглах талаар дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

#### **3.5.1 Илрүүлэлт:**

Төсвийн төлөвлөлтийг бодитой, үнэн зөв хийдэггүйгээс орлогын төлөвлөгөө бага төлөвлөгдөж, батлагдсан төлөвлөгөөг 7,870.9 мянган төгрөг буюу 91.5 хувиар давуулсан байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Төсвийн орлого дутуу төвлөрөх.

### 3.5.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн орлогыг бодитой төлөвлөх.

## **3.6 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

### 3.6.1 Илрүүлэлт:

Шатахууны зарцуулалтыг тогтоосон нормативаар тооцож хянахад замын хуудасны километрийн бичилт дутуу бичигдсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### 3.6.2 Эрсдэл:

Тээвэр шатахууны зардлыг батлагдсан төсвөөс үндэслэлгүй хэтрүүлэн зарцуулсан байх.

### 3.6.3 Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудасны бичилтийг сайжруулах, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

### 3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                                  | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл         |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>919,849,359.00</b> | <b>1,188,061,452.00</b> |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                                      | 919849359.00          | 1188061452.00           |
| 33300       | Татаас, санхүүжилтийн авлага                       | 99432286.00           | 37873700.00             |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                                | 183705.00             | 183705.00               |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага                         | 183705.00             | 183705.00               |
| <b>336</b>  | <b>Зээлийн авлага</b>                              | 820233368.00          | 1150004047.00           |
| <b>3361</b> | <b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>  | 820233368.00          | 1150004047.00           |
| 33612       | Хувь хүмүүст олгосон зээл                          | 820233368.00          | 1150004047.00           |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>919849359.00</b>   | <b>1188061452.00</b>    |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | <b>5389821.00</b>     | <b>5389821.00</b>       |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | 5389821.00            | 5389821.00              |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                                       | 5389821.00            | 5389821.00              |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                   |                       | 1585900.00              |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                                 | 5389821.00            | 3803921.00              |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг                           | 1585900.00            |                         |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг                           | 2836000.00            | 2836000.00              |
| 41363       | Татварын өглөг /ТӨҮГ/                              | 967921.00             | 967921.00               |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>914459538.00</b>   | <b>1182671631.00</b>    |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | 914459538.00          | 1182671631.00           |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | 914459538.00          | 1182671631.00           |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн                                 |                       | 914459538.00            |
| 51220       | Тайлант үеийн үр дүн                               | 914459538.00          | 268212093.00            |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>919849359.00</b>   | <b>1188061452.00</b>    |

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                               | <b>882868000.00</b> | <b>810470950.00</b>   |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>882868000.00</b> | <b>810470950.00</b>   |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                   | 49368000.00         | 16470950.00           |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 49368000.00         | 16470950.00           |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 49368000.00         | 16470950.00           |
| 123        | <b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>            | 833500000.00        | 794000000.00          |
| 123003     | Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг           | 833500000.00        | 794000000.00          |
| 2          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                   | <b>453649959.75</b> | <b>542258857.00</b>   |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>453649959.75</b> | <b>542258857.00</b>   |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 3973500.00          | 3900000.00            |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 3973500.00          | 3900000.00            |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3973500.00          | 3900000.00            |
| 213        | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 449676459.75        | 538358857.00          |
| 2133       | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 449676459.75        | 538358857.00          |
| 213301     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 233553511.00        | 193324235.00          |
| 213303     | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 216122948.75        | 345034622.00          |
| 3          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>429218040.25</b> | <b>268212093.00</b>   |
| 5          | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>429218040.25</b> | <b>268212093.00</b>   |

/Төгрөгөөр/

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл  | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                |                      |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                        | <b>1060617245.75</b> | <b>1159132557.00</b>  |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>1060617245.75</b> | <b>1059700271.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                   | 227117245.75         | 265700271.00          |
| 120004      | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                              | 227117245.75         | 265700271.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 177716245.75         | 249229321.00          |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 49401000.00          | 16470950.00           |
| <b>123</b>  | <b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>            | 833500000.00         | 794000000.00          |
| 123003      | Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг           | 833500000.00         | 794000000.00          |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                 | <b>0.00</b>          | <b>99432286.00</b>    |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                       | 0.00                 | 99432286.00           |
| 131009      | Оны эхний үлдэгдлээс санхүүжих                                       |                      | 99432286.00           |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                         | <b>1060617245.75</b> | <b>1159132557.00</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1060617245.75</b> | <b>1159132557.00</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>3973500.00</b>    | <b>3900000.00</b>     |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 3973500.00           | 3900000.00            |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3973500.00           | 3900000.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>1056643745.75</b> | <b>1155232557.00</b>  |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 88437989.00          | 133679001.00          |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 88437989.00          | 133679001.00          |
| <b>2135</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>            | 968205756.75         | 1021553556.00         |
| 213501      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 741088511.00         | 772324235.00          |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 227117245.75         | 249229321.00          |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                     | 0.00                 | 0.00                  |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>              |                      | 0.00                  |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>             |                      | 0.00                  |

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт                                     | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн       | Бусад       | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------------|-------------|---|
| C07 | Тайлант үеийн үр дүн                         |                                 |                       | 914,459,538.00          |             | 914,459,538.00                          |
| C08 | <b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>0.00</b>                     | <b>0.00</b>           | <b>914,459,538.00</b>   | <b>0.00</b> | 914,459,538.00                          |
| D01 | <b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>0.00</b>                     | <b>0.00</b>           | <b>0.00</b>             | <b>0.00</b> | 914,459,538.00                          |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>            | <b>0.00</b>                     | <b>0.00</b>           | <b>914,459,538.00</b>   | <b>0.00</b> | 914,459,538.00                          |
| D08 | Тайлант үеийн үр дүн                         |                                 |                       | 268,212,093.00          |             | 268,212,093.00                          |
| D09 | <b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>0.00</b>                     | <b>0.00</b>           | <b>1,182,671,631.00</b> | <b>0.00</b> | 1,182,671,631.00                        |

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Өмнөх оны             |              | Тайлант оны           |              |
|-----------------------|--|-----------------------|--------------|-----------------------|--------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл    | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл    |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                       |              |                       |              |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 886519999.00          | 745062011.00 | 897612580.00          | 776224235.00 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 365519999.00          | 268062011.00 | 318612580.00          | 197224235.00 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 365519999.00          | 268062011.00 | 318612580.00          | 197224235.00 |
| 2108                  | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 365519999.00          | 268062011.00 | 318612580.00          | 197224235.00 |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 365519999.00          | 268062011.00 | 318612580.00          | 197224235.00 |
| 23                    | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>                    | 521000000.00          | 477000000.00 | 579000000.00          | 579000000.00 |
| 230001                | Эргэж төлөгдөх зээл  | 521000000.00          | 477000000.00 | 579000000.00          | 579000000.00 |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 0.00                  | 315555234.75 | 0.00                  | 365132557.00 |
| 120004                | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | 0.00                  | 315555234.75 | 0.00                  | 365132557.00 |
| 1200041               | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |                       | 177749245.8  |                       | 249229321.00 |
| 1200042               | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |                       | 49368000.00  |                       | 16470950.00  |
| 1200043               | Урьд оны үлдэгдлээс санхүүжих  |                       | 88437989.00  |                       | 99432286.00  |